

ХУВЬ ХҮНИЙ МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАХ, БОЛОВСРУУЛАХ ЗӨВШӨӨРӨЛ

Би энэхүү баримт бичгээр, өөрийн чөлөөт хүсэл зориг, өөрийн ашиг сонирхлын үүднээс, Монгол Улсын хууль тогтоомж болон холбогдох бусад эрх зүйн актуудын дагуу Захиалагч («Мон’дэлис Казахстан» ХХН), Зохион байгуулагч («Urban Media» ХХН (Урбан Медиа)), Оператор («Lotus Media» ХХК (Лотус Медиа)) нарт “Alpen Gold Mongolia: илүү боломж, илүү бэлэг” сурталчилгааны урамшуулалт аян (1C46AH93)-ы хүрээнд миний хувийн мэдээллийг (цаашид “Хувийн мэдээлэл” гэх) цуглуулах, боловсруулахад **ямар нэгэн нөхцөлгүйгээр, бүрэн зөвшөөрөл** олгож байна.

Хувийн мэдээллийг дараах зорилгоор боловсруулахыг зөвшөөрч байна. Үүнд: шагнал илгээх, ялалтын тухай мэдэгдэх, Захиалагчийн бүтээгдэхүүн болон түүний зохион байгуулж буй арга хэмжээний талаарх мэдээлэл, сурталчилгааны санал хүргэх, маркетингийн шинжилгээ хийх, статистик мэдээлэл бэлтгэх, татварын үүргийг хэрэгжүүлэх, мөн Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлэн шаардлагатай бусад аливаа зорилгыг хэрэгжүүлэх.

Энэхүү зөвшөөрөл нь дараах хувийн мэдээлэлд хамаарна. Үүнд: овог, нэр, эцгийн нэр; регистрийн дугаар; холбоо барих мэдээлэл (оршин суугаа хаяг, шагнал хүргэх хаяг, цахим шуудангийн хаяг, гар утасны дугаар); Монгол Улсын иргэний үнэмлэхэд тусгагдсан мэдээлэл, мөн миний сайн дураар өгсөн бусад аливаа хувийн мэдээлэл.

Би Захиалагч, Зохион байгуулагч, Оператор нарт миний хувийн мэдээлэлтэй дараах үйлдлүүдийг автоматжуулсан, автоматжуулалтад хамрагдаагүй, эсхүл холимог аргаар гүйцэтгэхийг зөвшөөрч байна. Үүнд: цуглуулах, бүртгэх, системчлэх, хуримтлуулах, хадгалах, тодруулах (шинэчлэх, өөрчлөх), нөхөх, ашиглах, гарган авах, түгээх, нэргүйжүүлэх, хаах, устгах, мөн Монгол Улсын хүчин төгөлдөр хууль тогтоомжийг харгалзан гадаад улс орнуудын нутаг дэвсгэрт хил дамнасан байдлаар шилжүүлэх болон хувийн мэдээлэлтэй холбоотой бусад бүх үйлдлийг гүйцэтгэх.

Мөн миний хувийн мэдээллийг дээр дурдсан зорилгод хүрэхийн тулд нууцлалыг хадгалах, аюулгүй байдлыг хангах нөхцөлтэйгөөр гуравдагч этгээдэд дамжуулж болохыг зөвшөөрч байна. Үүнд, үүгээр хязгаарлагдахгүйгээр Mondelēz International компанийн группийн гишүүд, түүнчлэн Захиалагч, Зохион байгуулагч, Операторын даалгаврын дагуу хувийн мэдээлэл боловсруулдаг бусад этгээдүүд, түүний дотор хил дамнасан мэдээлэл дамжуулалт орно.

Энэхүү зөвшөөрөл нь дээр дурдсан зорилгод хүрэх хүртэл, эсхүл миний зүгээс уг зөвшөөрлийг цуцлах хүртэл хүчинтэй байна.

Би энэхүү зөвшөөрлийг хүчинтэй байх хугацаанд хүссэн үедээ Захиалагчийн дараах цахим шуудангийн хаягт бичгээр мэдэгдэл илгээж цуцлах эрхтэй болохыг мэдэж байна: **consumercareeua@mdlz.com.**

Мөн Монгол Улсын хууль тогтоомжид харшлах тохиолдолд, эсхүл миний зүгээс Захиалагч, Зохион байгуулагч, Операторын өмнө биелүүлээгүй үүрэг хариуцлага байгаа нөхцөлд энэхүү хувийн мэдээлэл цуглуулах, боловсруулах зөвшөөрлийг цуцлах боломжгүй болохыг надад мэдэгдсэн болно.